

Сургууль анги сурагчийн нэр

Монгол хэл 5-р анги

Булаг

Гурван аянчин нэгэн булгийн дэргэд очтол “Надаас үлгэр жишээ ав.” гэсэн бичиг байхыг үзжээ.

Тэд ямар учиртай бичиг болохыг өөр өөрийнхөөрөө тайлбарлаж гэнэ. Эхний хүн “Гол горхи энэ булгаас эх авч, өргөн хөндийгөөр урсахдаа бусад голтой нэгдсээр их мөрөн болдог. Тийм учраас хэрэв баян больё гэж бодож байвал тасралтгүй ажилла хэмээн сургаж байна” гэв. Хоёр дахь хүн “Энэ бичиг өөр санааг илэрхийлж байна. Булгийн ус ирсэн бүхний цангааг тайлдаг. Тэгэхлээр хүнд тустай зүйл хийж бай гэж хэлж байна.гэв. Гурав дахь аянчин “Бид усыг хамгийн цэвэр тунгалаг булгаас нь уудаг. Булингартай усыг хүн байтугай амьтан ч уудаггүй биз дээ? Тэгэхээр надаас жишээ авч сэтгэлдээ булингаргүй, сэтгэлээ цэвэр ариун байлга гэж байгаа юм биш үү?” гэжээ.

1. Асуултын дагуу даалгаврыг гүйцэтгээрэй. **/5 оноо/**

А.Аль нь хоёр дахь аянчны тайлбар вэ?

А. Бусдыг ажигла

Б. Хүнд тустай зүйл хий

В. Үлгэр жишээ ав

В.Тохирох үгийг нөхөж бичээрэй.

Эхний аянчин булгийн _____ урсдаг шинжийг онцолсон

бол хоёр дахь хүн _____ -г онцолжээ. Харин гурав

дахь хүн булгийн _____ шинжийг онцолжээ.

С.Эхийн гол санааг илэрхийлэхэд хамгийн чухал гэж үзсэн хэсгээ эхээс сонгон, доогуур нь зурж тэмдэглэнэ үү.

2. Хүн ба амьтад булингартай ус уудаггүй учраас голын усыг цэвэр, тунгалаг байлгахыг уриалсан 25-30 үгтэй эх зохион бичээрэй. **/3оноо/**

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

3. Дээрх эхээс: **/2 оноо/**

- Нэг үүрэгтэй балархай эгшиг гээгдэж бичигдсэн үг 2-ыг бичнэ үү!

- Хоёр үүрэгтэй балархай эгшиг гээгээгүй бичсэн үг 2-ыг бичнэ үү!

4.“танхим+ын, анир+аар” үгсийн зөв бичих дүрмийг тайлбарлана уу **/1 оноо/**


5.Онсогыг тааж хариуг бичнэ үү? яагаад ингэж бодсоноо тайлбарлана уу? **/1оноо/**

Төрөхөд өгдөг

Үхэхэд үлддэг (.....)

Би..... гэж бодож байна.

6. Үлгэрт гардаг дараах баатруудыг ажиглаад, бодит байдлыг дүрсэлсэн бол-**Б**, уран сэтгэмжийг илэрхийлсэн бол -**У** үсгээр тэмдэглэнэ үү? **\ 2 оноо **



7. Тохирох хэлц үгээр солин өгүүлбэрийг найруулж бичээрэй. **/1 оноо/**

Эмгэн, өвгөн хоёрын **санаа зовж** байсан ч хүүгээ явуулжээ.

Эмгэн, өвгөн хоёрын байсан ч хүүгээ явуулжээ.

8. Дараах хэлц үгийн **ойролцоо утгатай хэлц үг** олж бичээрэй. **/2 оноо/**

Ганзага нийлэх

Зүрх алдах

Хорголоо тоолох

Бүлх залгисан мэт

9. Утга нь ойролцоо, хэлбэр нь ижил зүйр үг зохиогоорой. **/2 оноо/**

Насны багад эрдэм сурахад

Залхуугүй бол нэн сайн

10. Үгсэд урт эгшгээр эхэлсэн нөхцөл залган бичээд зөв бичих дүрмийг тайлбарлаарай. **/4оноо/**

уншсан.....

хөрөөдөх.....

булаг.....

Гэрэл.....

Дорноговь.....

хармаг.....



уриалга

хөдөлмөр.....

Сургууль анги сурагчийн нэр


Математик 5-р анги

1. Будсан хэсэг нь 0.8 гэсэн бутархайг илэрхийлсэн зураг аль нь вэ? **/1 оноо/**



2. 2 м.кв хэдэн см.кв болох вэ? **/1 оноо/**
A. 20 см.кв B. 200 см.кв C. 2000 см.кв D. 20000 см.кв

3. Зургийг ажиглаад үнэн өгүүлбэрийг сонгоорой. **/1 оноо/**




- A. Энэ биет куб юм. B. Энэ биет дөрвөн оройтой.
C. Энэ биет найман ирмэгтэй. D. Энэ биет зургаан талстай.



4. Хоёр тооны нийлбэр 2304. Тэдгээрийн ноогдвор 8 бол уул 2 тоог олоорой. **/2 оноо/**

.....
.....
.....

5. Будсан гурвалжинг цагийн зүүний дагуу 90° эргүүлсэн зургийг сонгоорой. **/1 оноо/**



6. Зургаан өнцөгт тус бүрийн периметр 24 см болно. Зурагдсан дүрсийн периметрийг олоорой. **/2 оноо/**



7. Тэгш өнцөгт параллелолипед хэлбэртэй тасалгааны эзлэхүүн нь 60м.куб.
а. Тасалгааны өндөр 3м бол шалны талбайг олоорой. **/1 оноо/**

б. Өрөөний урт нь 5м бол өргөнийг олоорой. **/1 оноо/**

с. Тасалгааны жижиг ханын талбай хэд вэ? **/1 оноо/**

.....

8. Сантиметрээр илэрхийлээрэй.

3.4дм=

9.8м=

5.50мм=

/1.5 оноо/

9. 12 ба 15 тоонуудын хуваагчдыг Эйлер-Веннийн диаграмм дээр дүрсэлж, хамгийн их ерөнхий хуваагчийг олоорой.

/1.5 оноо/

10. $23.7 \times 100 : 10 + 56.8 - 8.06 =$

/2 оноо/


.....

.....

.....

11. Өгсөн дүрсүүдийг шинжээр нь зөв ангилсан хүснэгтийг олоорой.

/2 оноо/



A.

	4 өнцөгт	4-өөс олон өнцөгтэй
Бүх тал нь тэнцүү	A, F	D
Бүх тал нь тэнцүү биш	C, E	B

B.

	4 өнцөгт	4-өөс олон өнцөгтэй
Бүх тал нь тэнцүү	A, F	B
Бүх тал нь тэнцүү биш	C, E	D

C.

	4 өнцөгт	4-өөс олон өнцөгтэй
Бүх тал нь тэнцүү	A, C	D
Бүх тал нь тэнцүү биш	F, E	B

D.

	4 өнцөгт	4-өөс олон өнцөгтэй
Бүх тал нь тэнцүү	A, F, C	D
Бүх тал нь тэнцүү биш	E,	B

12. 3 зайрмаг 5 чихэр 4550 төгрөг. Харин 5 чихэр 5 зайрмаг 6750 төгрөг бол зайрмагны үнийг олоорой.

/3 оноо/

.....

.....

.....

.....

13. Дараах хүснэгтээр бод малын бүртгэлийг харуулжээ. Малын нийт тоог олоорой. **/1 оноо/**

Тэмээ	
Үхэр	
Адуу	

	- 10 мал;
	- 5 малыг төлөөлнө.

A. 14 B. 130 C. 120 D. 140